



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 04 сарын 11 өдөр

Дугаар 18/478

Улаанбаатар хот

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.4, 63.1.5 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, мөн зүйлийн 14.4 дэх хэсэг, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.6 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.7 дахь хэсэг, 48 дугаар зүйлийн 48.3 дахь хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 25/50 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2025 онд хэрэгжүүлэх “Гэрлэх ёслолын ордон”-ны зураг төсөв, барилгын их засварын ажлын жагсаалтыг хавсралтаар баталж, уг төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны эрхийг “Гэрлэх ёслолын ордон” ОНӨААТҮГ (Ү.Оюунзул)-т шилжүүлэн, худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журамд нийцүүлэн зохион байгуулж, үр дүнг танилцуулж ажиллахыг даалгасугай.

2. Энэ захирамжийн хавсралтад заасан төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхэд шаардлагатай 1,600,000,000.0 (нэг тэрбум зургаан зуун сая) төгрөгийг “Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 оны төсвийн жилд хэрэгжүүлэх барилга байгууламж, төсөл, арга хэмжээний жагсаалт”-ын “55”-д заасан “Гэрлэх ёслолын ордон”-ны зураг төсөв, их засварын ажлын хөрөнгөөс гүйцэтгэлээр нь холбогдох хууль, журмын дагуу хянан баталгаажуулж, санхүүжилтийн эрх нээхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын Хөрөнгө оруулалтын хэлтэс (Б.Гантулга)-т, нээсэн эрхийг үндэслэн батлагдсан төсвийн сар, улирлын хуваарийн дагуу санхүүжүүлэхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газар (Л.Эрдэнэбадрах)-т, захиалагчийн хяналт тавьж ажиллахыг “Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ (Б.Мөнхбат)-т, хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийг зохих журмын дагуу бүртгэлжүүлж, хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар (В.Оюумаа)-т тус тус даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар ханган ажиллахыг Нийслэлийн Засаг даргын нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан орлогч А.Амартүвшинд даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ

Х.НЯМБААТАР

1725022287

Нийслэлийн Засаг даргын 2025 оны
04 дүгээр сарын 11-ны өдрийн
А/НТБ зураг захирамжийн
хавсралт

НИЙСЛЭЛИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ
“ГЭРЛЭХ ЁСЛОЛЫН ОРДОН”-НЫ ЗУРАГ ТӨСӨВ, БАРИЛГЫН
ИХ ЗАСВАРЫН АЖЛЫН ЖАГСААЛТ

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр	Хугацаа		Төсөвт өртөг	(сая төгрөг) 2025 онд санхүүжиг х дүн
		Эхлэх	Дуусах		
1	“Гэрлэх ёслолын ордон”-ны барилгын дээвэр, танхимыг шинэчлэх зураг төслийн ажил (Улаанбаатар хот)	2025	2025	600.0	600.0
2	“Гэрлэх ёслолын ордон”-ны барилга, сантехник, цахилгааны засварын ажил (Улаанбаатар хот)	2025	2025	1,000.0	1,000.0
Нийт дүн				1,600.0	1,600.0



نقدہیں ہر قسم کی صورت و حد
کے تحت

میتنسونیتسون

مفتی

۵۵۵۵۵ ۵۵ ۵۵
 رقم و رقم ۵۵ رقم

بِسْمِ اللَّهِ الرَّحْمَنِ الرَّحِيمِ

[illegible][illegible][illegible]

